

# ЭХНЭР, НӨХӨР, ЭЦЭГ ЭХ, ҮР ХҮҮХЭДТЭЙГЭЭ ХАРИЛЦАХ

---

Багш Д.Уранцэцэг

# ЭЦЭГ ЭХ, ҮР ХҮҮХДИЙН ӨВ ТЭГШ ХАРИЛЦААНЫ ОНЦЛОГ





# ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААГ ХҮНДРҮҮЛДЭГ ЗҮЙЛ

---

- тушаах
- шууд зааварчлах
- болгоомжлох
- зэмлэх
- сөрөг үнэлгээг шууд өгөх
- тохуурхах
- нэр хаяг зүүх
- мөрдөх
- байцаах
- анхаарал халамж сулрах
- асуудлаас зугтах гэх мэт зүйлүүд

## ДАСГАЛ-2

Эр хүний эрхэмлэх 5 шинж:

1. Алсын хараатай
2. Холч ухаантай
3. Өршөөнгүй сэтгэлтэй
4. Эв найртай
5. Эрхэм ёсыг сахисан

Эхнэр хүний эрхэмлэх 9 эрдэм:

1. Өнгөнд цэвэр
2. Үйлэнд уран
3. Үрдээ энэрэлтэй
4. Үргэлж цэмцгэр
5. Ханьдаа түшигтэй
6. Хадамдаа элэгтэй
7. Найранд дуутай
8. Настанд ерөөлтэй
9. Нартад буянтай



**Эхнэр, нөхөр бие биедээ нөлөөлсөөр аажимдаа нэг хүн шиг болдог.  
Чухам яаж нөлөөлдөг вэ?**

Эхнэр хүний нөхөртөө үзүүлэх нөлөөлөл:

- Ханилсан ханиараа гоёх, бахархах мэдрэмжийг нь хэвээр байлгахыг хичээх;
- Гэр орноо цэвэр, эмх цэгцтэй, дулаан тохитой, амар тайван байлгах;
- Нөхөртөө хүндлэлтэй хандах, дэмжин урамшуулах, хайраар дүүрэн байлгах;
- Гэр бүлдээ зөөлөн дулаан уур амьсгал бүрдүүлэх, асуудлыг намжаах, амар тайвныг эрхэмлэгч байх;
- Эдийн засгийн чадавхаа тооцоолон, ойр холын тооцоо төлөвлөгөөтэй байх;
- Сайн аав байхад нь зүй ёсоор туслах, хүүхдэдээ аавынх талаар сайнаар ярьж ойлгуулах;

Нөхөр хүний эхнэртээ гаргаж байгаа зан чанар, эхнэртэйгээ харилцаж байгаа харилцаа зэрэг нь эхнэр хүний зан чанарт асар их нөлөөлдөг.

- Эхнэртээ буулт хийж, санаа тавьдаг байх нь эхнэр тайван амгалан, хүлээцтэй, ямар ч үед нөхрөө ойлгоход тустай.
- Эхнэрээ үл тоож анхаарал халамж тавихгүй байснаар эхнэрийн зан чанарт гутранги үзэл суухаас гадна өөрийгөө үнэлэх үнэлэмж буурдаг.
- Эхнэр болон гэр бүлийн гишүүдэд дарамт үзүүлснээр эхнэр уур уцаартай, ямарваа нэгэн юмыг үл ойшоосон болгоход нөлөөлдөг.
- Эхнэртээ хэт номхон дорой хандсанаар эхнэрийн зан төлөвт үл тоосон, санаа бодлыг нь хүндэлдэггүй болгодог.

Гэр бүлийн харилцааг эрхэмлэснээр амар амгалан, бие биедээ халамжтай, эелдэг найрсаг харилцааг бүрдүүлсэн гэр бүл болно.

# ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУД

---





# ДАСГАЛ -1

Ноён хутагт Д.Равжаагийн зохиосон “Цаасан шувуу” сургаалаас:

<b>Гадаад биеийн явдал хэмээвээс</b>	<b>Хэлний өгүүлэх хэмээвээс</b>	<b>Сэтгэлийн чиг хэмээвээс</b>
<ul style="list-style-type: none"><li>- Ёстныг хүндэл.</li><li>- Настныг баярлуул.</li><li>- Ачтанаа өргө.</li><li>- Бачтанаас зайл.</li><li>- Сайнаас бүү сал.</li><li>- Олныг бүү арилж.</li><li>- Огт бүү харамла.</li><li>- Олон дараагаар хэрэггүй явдлыг бүү арвитга.</li><li>- Онц зөрүүлхэж дээдсээс бүү сал.</li><li>- Муу нөхөртэй бүү нөхөц.</li><li>- Зүйл бүрийн хувцас бүү өмс.</li><li>- Зүг талгүй бүү гайхуул.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Хэрцгийрхэж хэрүүл бүү үүсгэ.</li><li>- Хэгжүүрхэж омог бүү үүсгэ.</li><li>- Хэлбэрч олон янз бүү урва.</li><li>- Хоцорч нөхөргүй бүү суу .</li><li>- Саваагүй тоглоом бүү тогло.</li><li>- Санамсаргүй үг бүү хэл.</li><li>- Эвлэж муу санаатантай бүү зөвш.</li><li>- Эвдэрч олон зан бүү гарга.</li><li>- Хордож бусдын гэмийг бүү малт.</li><li>- Ховсорч хэрэггүй үг бүү зөө.</li><li>- Хуурч элдэв башир бүү хэл.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Шинжлэлгүй бүү сэтгэ.</li><li>- Сэрэмжгүй бүү залхайр.</li><li>- Гэнэт нөхөрт бүү итгэ.</li><li>- Гэнэдэж хүнээс бүү урьт.</li><li>- Буруу юмыг бүү өмөөр.</li><li>- Бусдын юманд бүү шуна.</li><li>- Бузгай дээрэнгүй бүү загна.</li><li>- Бузар хилэнцийг бүү үүсгэ.</li><li>- Чөлөөгүй гэж бүү алгас.</li><li>- Чадалгүй байж бусдыг бүү дуурай.</li><li>- Магад дээдсийг олж нөхөрлө.</li><li>- Муу явдалтнаас насад дутаа.</li><li>- Буянтай санаанаас бүү холд.</li><li>- Бодь сэтгэлийг бүү март.</li></ul>

## ДАСГАЛ -2

<b>Тохиолдол</b>	<b>Харилцаанд анхаарах зүйл</b>
<p>Б: Бага байхаасаа эцэг, эхийнхээ зөвлөж буй мэргэжилтэй хүн болно гэж боддог байсан ч ахлах ангид орсноор өөр мэргэжилтэй хүн болохыг хүссэн ч энэ үед эцэг, эх нь түүнийг найз нөхдөө дуурайж байна гэж зэмлэжээ.</p>	
<p>Ц: Эцэг эхтэйгээ маш дотно харилцаатай байсан ч нас нэмэх тусам эцэг эх нь түүнд тавих анхаарал суларч, тэр өөрөө ч харилцах сонирхолгүй болов.</p>	
<p>Г: Нийгмийн идэвх сайтай сурагч. Гэвч тэрээр айлын том охин тул гэр орондоо их цаг зарцуулах нь түүнд ачаалал өгч ядраадаг.</p>	



Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин  
шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг  
хориглоно

Гэр бүл нь нийгмийн  
үндсэн нэгж мөн

Гэр бүл, эх нялхас, хүүхдийн  
ашиг сонирхлыг төр  
хамгаална.

Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл  
чийрэг өсгөн хүмүүжүүлэх,  
хөгжүүлэх, түүний эрх, ашиг  
сонирхлыг нь нэн тэргүүнд  
хамгаалахыг эрхэмлэнэ.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэр  
бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй  
адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Гэр бүлийн  
харилцааны  
зарчим

- <https://medle.mn/telelesson/10/245/1442>